# ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.БАТМӨНХИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.06.10 Улаанбаатар хот

| Д/д | Үзүүлэлт | Суурь түвшин /2024 оны эхний хагас жил/ | Зорилтот түвшин Эхний хагас жил | Биелэлт | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал | 1.Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, химийн болон цацрагийн осол хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт /-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр гаалийн газар, хороодод чиглэл өгч, хариу арга хэмжээг авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав.<br>Улаанбаатар Гаалийн газраас Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газартай хамтран 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан “Малын гоц халдварт “шүлхий” өвчин, гаалийн хяналтын бүсэд гарсан | 1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс, химийн болон цацрагийн осол, хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт /-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны талаар харьяа гаалийн газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар тухай бүр хангаж ажиллана.<br><br>2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын мэдээг мэргэжлийн байгууллагаас авч, ГЕГ-ын удирдлага болон харьяа гаалийн газар, хорооодод шуурхай хүргэж, хариу арга хэмжээ авах чиглэлийг хүргүүлнэ.<br><br>3. Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдод тавьж буй эрүүл мэндийн хяналт тандалтын мэдээг улирал бүр нэгтгэн ГЕГ-ын удирдлага, холбогдох мэргэжлийн байгууллагуудад, сэжигтэй | 1.Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005), Монгол Улсын шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын дагуу улаанбурхан халдварт өвчний нөхцөл, авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний хүрээнд Монгол Улсын агаарын замын боомтоор дээрх өвчний дэгдэлт өндөртэй бүс нутгуудаас ирж буй нислэгийн зорчигчдод эрүүл мэндийн тандалт судалгааг /термокамер, эрүүл мэндийн мэдүүлгийн хуудас/ хийж ажиллахад мэргэжлийн удирдлагаар хангасан.<br>“Нүүдэлчин агро ферм” ХХК-ийн Бүгд Найрамдах Беларусь Улсаас 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр импортлон Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 24-5069 тоот, шинжилгээний дүнгээр 10 адуунаас хачгийн халуун /B.caballi/, 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 24-5113 тоот шинжилгээний дүнгээр 14 адуунд папиллома вирус илэрсэн тул МЭЕГ-аас ирүүлсэн чиглэлийн мөрөөр Сэлэнгэ аймгийн гаалийн газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 02-1/289 дугааартай албан бичгээр халдварт өвчинтэй гарсан 17 толгой адууг Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын “Газрын амьтны эрүүл мэндийн кодекс”-ын 12.7.2, “Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 15.2 дахь заалтуудыг үндэслэн, шийдвэрлэх тухай чиглэлийг хүргүүлсэн.<br>Тус аж ахуй нэгжид Сэлэнгэ аймгийн Гаалийн газраас 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зөрчлийн хэрэг нээж, хэрэг бүртгэлийн шатанд явж буй талаар 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр 02-1.2/1224 дугаартай албан бичгийг дахин хүргүүлсэн. | 95 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний үзүүлэх сургалтад санал өгч оролцсон.<br><br>Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдод тавигдаж буй эрүүл мэндийн хяналт тандалтын мэдээг сар бүр нэгтгэхэд 2024 оны эхний 6 сарын байдлаар буюу эхний хагас жилд Монгол Улсын хилээр орсон 1,055965 (дотоод 825084, гадаад 230881), улсын хилээр гарсан 986931 (дотоод 822908, гадаад 164023) зорчигчдод эрүүл мэндийн хяналт, тандалтыг хийсэн нь өнгөрсөн мөн үеэс 60 хувиар нэмэгдсэн бөгөөд хяналт тандалтын дүнгээр олон улсын хөл хориот өвчний сэжигтэй тохиолдол илрээгүй байна.<br><br>3.Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудаст нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн 115 дугаар тушаалаар батлагдсан “Хилийн хорио цээрийг цахимжуулах ажлын хэсэг”-т өгч, программын даалгаврыг бэлэн болж, халдварт өвчний дэлхий | үйл явдал, тохиолдлын мэдээг тухай бүр мэдээлнэ.<br><br>4.”Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудас”-ыг SPS төслийн хүрээнд цахимжуулж, ХХЕГ-тай зорчигч, тээврийн хэрэгслийн өдөр тутмын хөдөлгөөний мэдээлэл, ЭМЯ-тай сэжигтэй үйл явдал, тохиолдлын үеийн зорчигчийн дэлгэрэнгүй мэдээллийг солилцох шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.<br><br>6.Нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлын өөрийн үнэлгээний аргачлалыг боловсруулж батлуулан, олон улсын шинжтэй автозамын 2 боомт, хоёр талын шинжтэй автозамын 2 боомт, олон улсын агаарын хилийн 1 боомт, нийт 5 боомтод үнэлгээ хийж, тайлагнана.<br><br>8. МУ-ын Гаалийн ерөнхий газар, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын “Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Замын-Үүдийн нутаг дэвсгэр болон БНХАУ-тай хиллэдэг зарим нутаг дэвсгэрт 2 улсын мэргэжлийн байгууллагатай хамтран зоонозын халдварт өвчний тандалтыг хийнэ. | Европын Холбооны гишүүн орнуудад малын гоц халдварт шүлхий өвчний тохиолдлууд бүртгэгдсэнийг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас мэдээлсэнтэй холбогдуулан Европын Холбооны гишүүн орнуудаас Беларусь Улсад үхэр, бог мал нэвтрүүлэхийг, түүнчлэн тус улсын нутаг дэвсгэрээр транзит тээвэрлэлт хийхийг 2025 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн түр хугацаагаар хязгаарлах болсонтой холбогдуулан Сэлэнгэ аймгийн гаалийн газарт мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг тавих хяналтыг чангатгах талаар чиглэл хүргүүлсэн.<br><br>Сэлэнгэ аймгийн гаалийн газарт , 2025.01.20-ны өдөр 02-1/289 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлсэн. УХШИГГ-ын мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдад үйл ажиллагаатайгаа нь холбоотой 2 удаагийн зөвлөгөө, мэдээлэл, чиглэлийг өгч ажилласан.<br><br>Замын-Үүд боомтоор “Эм И Ай Эл интернэйшнл” ХХК-ний Энэтхэг Улсаас импортлогдсон 75 тн цагаан будаанд гадаад хорио цээртэй Гурилын жижиг жуулгавч, Суринамын гурилч цох илэрсэн тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу экспортлогч улсад буцаах, эсхүл буцаах үүргээ биелүүлэхгүй бол хуульд заасны дагуу шилжүүлэн устгах арга хэмжээг авч ажиллах талаар Замын-Үүд дэх Гаалийн газарт 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 02-1.2/1619 тоот, БНЭнэтхэг Улсаас МУ-д суугаа Элчин сайдын яаманд 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 02/2286 тоотоор тус тус чиглэл хүргүүлж ажилласан.<br><br>Замын-Үүд боомтоор 1 дүгээр сард 22 тн цагаан будаанаас МУ-ын хилээр нэвтрүүлэхийг хориглосон хорио цээртэй шавж болох Цагаан будааны шөвгөр хошуут цох /Sitophilus oryze L/ -6ш илэрч, экспортлогч улсад буцаах талаар чиглэлийг Замын-Үүд Гаалийн газарт өгсөн.<br><br>2.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын мэдээг ХӨСҮТ болон бусад мэргэжлийн байгууллагаас авч, ГЕГ-ын удирдлага болон харьяа гаалийн газар, хорооодод 44 удаа хүргэж, хариу арга хэмжээ авах чиглэлийг хүргүүлсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дахины болон Монгол Улсын нөхцөл байдал харьцангуй тайван байгаатай холбогдуулан хилээр нэвтэрч буй зорчигч, аялагчдаар эрүүл мэндийн хуудсыг бөглүүлээгүй байна.<br><br>4.Халдваргүйжүүлэлт, шарилын бүртгэл, түр тусгаарлалт, зорчигч, тээврийн хэрэгслийн эрүүл мэндийн хяналтыг захиргааны статистикийн бүртгэлийн мэдээнд оруулах программын даалгаврыг боловсруулж, ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн 115 дугаар тушаалаар батлагдсан "Хилийн хорио цээрийг цахимжуулах ажлын хэсэг"-т хүлээлгэн өгсөн.<br>Хүрсэн үр дүн:<br>Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авч хэрэгжүүлсэн дээрх зөвлөмж, чиглэлийг Гаалийн газар, хороодод хүргүүлж ажилласнаар улсын хил, гаалийн хяналтын бүсээр хүний олон улсын хөл хориот өвчин, мал амьтны гоц халдварт өвчин дамжин тархаагүй, хими, цацрагийн осол, хордлого гараагүй. | | 3. Монгол Улсын хилээр гарсан 1248258 (дотоод 1011123, гадаад 237,135) улсын хилээр орсон 1319625 (дотоод 1035901, гадаад 283724) зорчигчдод Олон улсын хөл хориот хүний өвчний сэжигтэй тохиолдол илрээгүй байна.<br>Хилийн нэвтрэх цэгт халдварт өвчний нөхцөл, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний өдөр тутмын мэдээг албан ёсны Quarantine.health@customs.gov.mn цахим хаягаар авч, ЭМЯ, ХӨСҮТ-тэй мэдээллийг солилцон ажилласан.<br><br>4. Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудсыг бүрэн цахимжуулах ажлын талаар ЭМЯ-ны мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, гаалийн газар, хороодод 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн шуурхай хуралдаанаар халдварын эсрэг хариу арга хэмжээний чиглэлийг өгч, Иргэний нисэхийн ерөнхий газарт цаад талдаа нислэгт суухаас өмнө эрүүл мэндийн мэдүүлэг хуудас бөглүүлэх зэрэг хамтран ажиллах асуудлаар 2025 оны 02 дугаар 25-ны өдрийн 02/893 тоот албан бичгийг хүргүүлж, одоогоор QR код бүхий эрүүл мэндийн цахим хуудсыг бөглүүлж, эрсдэлтэй үеийн бэлэн байдлыг хангасан. Чингис хаан дээр туршилтаар нэвтрүүлсэн.<br><br>6. Гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний 1.2.3 дугаар заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Хилийн Ханги, Замын-Үүд боомтод "Хилийн нэвтрэх цэгийн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл явдлыг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ"-г ХӨСҮТ, ЗӨСҮТ-тэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 16-ны өдрийг хүртэл зохион байгуулж, Ханги боомт 73 хувь, Замын-Үүд боомт 83 хувийн урьдчилсан дүнгээр үнэлэгдэв.<br>Замын-Үүд боомтод сум орон нутгийн түвшинд 3, боомтын хэмжээнд 2, гаалийн газрын хэмжээнд 6, Ханги боомтод сум орон нутгийн түвшинд 3, боомтын хэмжээнд 4, гаалийн газрын хэмжээнд 8 заалт бүхий зөвлөмжийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 02/ 2347, 02/2348 тоот албаг бичгээр тус тус хүргүүлж ажиллалаа.<br>Түүнчлэн 2025 оны 06 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд дээрх үнэлгээг Чингис хаан ОУНБ дээр хийж, үнэлгээний дүнг нэгтгэв. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 8. ГЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/176 тоот "Уулзалтад оролцуулах тухай" тушаалын дагуу МУ-ын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хооронд байгуулсан "2022 оны Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол"-ыг хэрэгжилтийг хангуулах хүрээнд ЗӨСҮТ, ХӨСҮТ-тэй хамтран, БНХАУ-ын Хөх хот, Эрээн ГГ-тай хамтран 2025 оны 05 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод болсон уулзалтад ХЦХ, Замын-Үүд ГГ-ын ХЦА-ны төлөөллүүдийн хамт оролцож, дээрх протоколын хэрэгжилтийн талаар Монголын талын илтгэл хэлэлцүүлэв.<br>Уулзалтын мөрөөр 4 заалтаар /Монгол, Хятадын хилийн боомтуудын мэрэгчээр дамжих зоонозын халдварт өвчний хамтарсан тандалт, хилийн эрүүл ахуй, хорио цээрийн асуудлаар хэлэлцээр, эрдэм шинжилгээний хурал, үзүүлэх сургууль/ 2025 онд ажлыг төлөвлөж, хурлын тэмдэглэлийг үйлдэж, Хөх хотын ГГ, МУ-ын ГЕГ-ын ХЦХ, ӨМӨЗО-ны Өвчнөөс урьдчилан сэргийлэх төв, МУ-ын ЗӨСҮТ-ийн талаас баталгаажуулж, 2025 оны 05-06 сард Хавирга-Архашаатын нутаг дэвсгэрт ЗӨСҮТ-тэй хамтарсан зоонозын халдварын тандалтыг хийсэн.<br><br>9. Амьтан, ургамал, зорчигчийн түр тусгаарлалтын модулыг ГЕГ-ын 115 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг хийж, дуусгасан гүйцэтгэл 100 хувьтай байна.<br><br>**Хүрсэн үр дүн:** Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, хариу арга хэмжээг бэлэн байдлыг хангах, тохиолдол илэрсэн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний зааварчилгааг харьяа гаалийн газар, хороодод тухай бүр өгч ажилласан. Зөөвөрлөгдсөн улаанбурханы эрсдэлийн хамтарсан үнэлгээнд 2 удаа оролцож, Хилийн нэвтрэх цэгийн стратегийн үнэлгээг 3 гаалийн газрын түвшинд хийж, хамтын ажиллагааны 1 хуралдаанд оролцож, гүйцэтгэлийн үр нөлөөг сайжруулсан.<br>2025 оны эхний хагас жилд Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг хүний хөл хориот өвчин хил дамжин тархаагүй. | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл | 1.Гаалийн системийн хэмжээнд 2024.01.01-ний өдрөөс 2024.06.05-ны өдөр хүртэл хялбаршуулсан журмаар | 1.Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан | 1. Харьяа гаалийн газар, хороодын 2025 оны эхний хагас жилийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нийт зөрчлийн тоо 1397 байна. Үүний 147 зөрчил буюу 10,5 %-ийг гаалийн хорио цээрийн хяналтаар илрүүлж, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийсэн байдал | шийдвэрлэсэн нийт зөрчлийн тоо 958 байна. Үүнээс 172 зөрчил буюу 18%-ийг гаалийн хорио цээрийн хэлтэс, албаны гаалийн улсын байцаагчдын илрүүлэн 107.6 сая төгрөгийн торгууль ногдуулж, шийдвэрлэсэн зөрчил ээлж байна.<br><br>2023.01.01-ний өдрөөс 2023.06.05-ны өдөр хүртэл хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нийт зөрчлийн тоо 793, үүнээс 132 зөрчил буюу 16.6%-ийг гаалийн хорио цээрийн хэлтэс, албаны гаалийн улсын байцаагчдын илрүүлэн 57.8 сая төгрөгийн торгууль ногдуулж, шийдвэрлэсэн зөрчил ээлж байсан.<br><br>2.ГЕГ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай уялдуулан ажиллаж, зохион байгуулалтын нэгжид 182 дотоод зурвас хүргүүлж, 122 дотоод зурвасыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Харъяа газар, хороодод 12 албан бичгийг чиглэл тус бүрээр хүргэж, мэргэжлийн зөвлөгөө өгсөн. | хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулах, харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.<br><br>2.Хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.<br><br>3.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамаарагдаг барааны 47 төрлийн зааврыг эцэслэн боловсруулан, баталгаажуулж, цахимаар ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.<br><br>4. БТКУС-ын 21 дүгээр бүлэг, 2106 (бусад газарт заагдаагүй хүнсний бүтээгдэхүүн) зүйлд хамаарах эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт зэрэг барааны гаалийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулна.<br><br>5.Зорчигчийн хувийн хэрэглээний эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлийг гаалийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-д холбож, нэвтрүүлнэ.<br><br>6.Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа, | холбогдох хууль тогтоомжийн дагуу 164.6 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна.<br><br>УИХ-ын даргын 2024 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Стандарт эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” ажлын хэсэг болон Шадар сайдын санаачлагаар 2025 оны 02 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулсан “Барилга, эм, хүнс-хүрээлэн буй орчин салбарын стандартын хэрэгжилт тулгамдаж буй асуудлын хэлэлцүүлэг”-т мэдээлэл чиглэл тус бүрээр мэдээлэл бэлтгэж, импортын хүнсний асуудлаар нэгдсэн зөвлөмжид холбогдох саналыг өгч ажиллав.<br><br>Мал эмнэлгийн ерөнхий газраас албан бичгээр ирүүлсэн "Экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэлд баталгаажуулах тэмдэг, гарын үсгийн баталгаа”-г гаалийн газар, хороодод 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 02-1,2/21712 албан бичгээр хүргүүлж чиглэл өгсөн.<br><br>Зорчигчийн эмийн бүртгэлийн системд дүн шинжилгээ хийж, харьяа гаалийн газар хороодын дарга нарт “Зорчигчийн хувийн хэрэглээний эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэл, хяналтыг сайжруулах тухай” 2025 оны 04 сарын 21-ний өдрийн 02-1.2/1592 тоот албан бичгийг харьяа гаалийн газар, хороодын дарга нарт хүргүүлсэн.<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай” 255 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтод 3 аж, ахуй нэгж, 1 иргэний адууны жүчээ, үхрийн фермийг гаалийн хорио цээрийн хяналтын түр бүсээр тогтоон цэвэр үүлдрийн адуу 222 толгой, сүүний чиглэлийн үхэр 123 толгой импортлоходхорио цээрийн анхдагч үзлэг, бичиг баримтын болон лабораторийн шинжилгээнд хамруулан гаалийн хяналтаас чөлөөлж, тухайн орон нутагт нь Засгийн даргын захирамжийг үндэслэн мал эмнэлгийн газарт хүлээлгэн өгч ажилласан.<br><br>Монгол улсаас Узбекстан улсад 2061 хонь, БНХАУ-д нядалгааны зориулалтаар 2860 толгой хонь, ямаа | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 5. Улсын хилээр орсон 446194 тээврийн хэрэгсэл (онгоц 1074, вагон зүтгүүр 1963, суудлын вагон 320, ачааны вагон 132195, суудлын машин 123745, ачааны машин 186897)-д урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх явцад хяналт тавьж ажилласан нь нондингийн мөн үетэй харьцуулахад 48,6 хувиар нэмэгдсэн байна. Улсын хилээр гарсан 508030 тээврийн хэрэгсэл (1074 онгоц, 1947 вагон зүтгүүр, суудлын вагон 320, 128541 ачааны вагон, 124675 суудлын машин, 251473 ачааны машин)-д хяналт тавьж ажилласан нь нондингийн мөн үетэй харьцуулахад 57,6 хувиар нэмэгдсэн байна<br><br>Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан 12 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцох, 6 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан нь өнгөрсөн мөн үетэй харьцуулахад уулзалт, хэлэлцүүлэг 2-оор нэмэгдэж, ажлын | тээврийн хэрэгслэлд урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдваргүйжүүлэлт хийсэн мэдээнд дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангана.<br><br>7.”Хүнсний сүлжээн дэх тээвэрлэлтийн ерөнхий шаардлага” стандартыг хангуулах тандалтын удирдамжийг боловсруулж, харьяа гаалийн газар, хороодод хүргүүлж, тандалтыг хийж, тайлагнана.<br><br>8.Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хаяг шошгололтод тандалт судалгаа хийх удирдамжийг боловсруулж, харьяа гаалийн газар, хороодод хүргүүлж, тандалтыг хийлгүүлэн, дүнг нэгтгэн, цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлнэ.<br><br>9.Гаалийн байгууллагын gaali.mn системийн “Аюулгүй байдлын мэдээ” талбарт хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг байршуулж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах, эргэн татах зэрэг шаардлагатай арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлж ажиллана. | экспортлоходд харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллав.<br><br>2.Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/676 дугаартай тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу Хорио цээрийн чиглэлийн 2024 оны 12 дугаар сарын статистик мэдээг нэгтгэж, Статистик, дүн шинжилгээний хэлтэст 2025 оны 01 сарын 08-ны өдөр, 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр 163 тоот, 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр 245 тоот , 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр 352 тоот , 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 515 тоот, 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр 662 тоот Дотоод зурвасуудаар Статистик, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэхэд хянаж баталгаажуулав.<br><br>3.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтынн тухайн чиглэлээр боловсрогдсон 28 цахим заавар хянагдаж, хяналтын үйл ажиллагаанд нэвтэрч эхэлсэн.<br><br>4. БТКУС-ын 21 дүгээр бүлэг, 2106 (бусад газарт заагдаагүй хүнсний бүтээгдэхүүн) зүйлд хамаарах барааны 2025.01.01-2025.01.28-2025.04.01 өдөр хүртэлх хугацаанд гаалийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-д 2106 (бусад газарт заагдаагүй хүнсний бүтээгдэхүүн)-ий мэдүүлэгт дүн шинжилгээ хийсэн. Дүн шинжилгээгээр 2106.90 БТКУС-ын кодтой барааны 3425 бичлэг CAIS-д бичигдсэн бөгөөд үүний 107 бичлэг нь 2106.90.11 кодтой бараа, 1442 бичлэг нь 2106.9019 кодтой бараа, 1876 бичлэг нь 2106.9090 кодтой бараагаар мэдүүлсэн байна.<br>Мэдүүлэгт хавсаргасан бичиг баримтаас харахад шаардлагатай бичиг баримт дутуу, чанарын шинжилгээний бичиг дутуу байх, шаардлагагүй илүү бичиг баримт хавсаргах зэрэг дутагдалтай талууд илэрсэн байна.<br><br>5.Зорчигчийн хувийн хэрэглээний эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлийг Гаалийн тухай хуулийн 227 дугаар зүйлийн 227.10 дахь заалтад заасны дагуу гаалийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-д эмэлт өөрчлөлт оруулж, харьяа гаалийн газар хороодод 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 02-1/604 тоот албан бичгээр чиглэл хүргүүлж, 2025 оны 02 дугаар сарын 05- | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байдал 1-ээр нэмэгдсэн байна.<br><br>2024 оны эхний хагас жилд төлөвлөсөн 1, төлөвлөгөөт бус 2 , нийт 3 сургалтыг хийсэн байна.<br>ХЦХ-ийн ГУБ нар 2024 оны эхний хагас жилд хорио цээрийн мэргэжлийн болон бусад чиглэлээр 11 сургалтад хамрагдсан байна. | 10. Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллана.<br><br>11.Батлагдсан төлөвлөгөөний дагуу харьяа гаалийн газар, хороодын улсын байцаагчдад сургалт зохион байгуулна | ны өдрөөс цахим системээр бүртгэж эхэлсэн бөгөөд эхний хагас жилийн байдлаар 259 зорчигчийн хувийн хэрэглээний эм болон эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн бүртгэгдсэн байна.<br><br>6. Улсын хилээр гарсан 459283 тээврийн хэрэгсэл (онгоц 2326, вагон 43993, суудлын машин 151207, ачааны машин 214791, автобус 19636, бусад 27330)-д урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх явцад хяналт тавьж ажилласан нь нондингийн мөн үетэй харьцуулахад 29 хувиар нэмэгдсэн байна. Улсын хилээр орсон 731690 тээврийн хэрэгсэл (онгоц 2326, вагон зүтгүүр, суудлын вагон 4118, суудлын машин 150753, ачааны машин 208943, автобус 19992, бусад-105)-д хяналт тавьж ажилласан нь нондингийн мөн үетэй харьцуулахад 36 хувиар нэмэгдсэн байна.<br>Хилийн боомтоор нэвтрүүлсэн 299283 тээврийн хэрэгслэлд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18 хувир өссөн дүнтэй байна.<br><br>7. Гаалийн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/30 дугаартай “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” тушаалыг боловсруулан батлуулж, тушаалын 1, 2 дугаар хавсралтаар ”Хүнсний сүлжээн дэх тээвэрлэлтийн ерөнхий шаардлага”, “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хаяг шошгололт”-ын удирдамжийг хүргүүлж, 1 дүгээр үе шатны хэрэгжилтийг гаргаж, харьяа гаалийн газар, хороодод чиглэл өгч ажилласан.<br><br>8.Тандалт судалгааны 1 дүгээр үе шатыг зохион байгуулж гаалийн газар, хороодын Хорио цээрийн албаны хүнсний чиглэлээр хяналт шалгалтад хамрагдсан нийт 954 аж ахуйн нэгжийн 1599 гаалийн мэдүүлгээр 10567 нэр төрлийн 93,7 мян.тн, 408.662 литр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд 9,9 тэрбум төгрөгийн гаалийн болон бусад татвар хураамжийн орлого төвлөрүүлсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тандалт судалгааг хийж мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэн.<br>Тандалт, судалгаанд хамрагдсан хүнсний барааны сав баглаа боодол шошголoлтын байдлаар авч үзэхэд: зориулалтын сав баглаа боодолтой 22477, Шошгод агуулагдах мэдээллийг агуулсан 19192, Шошгод | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | агуулагдах мэдээллийг агуулаагүй 330, шошгын мэдээлэл нь англи хэлээр 16307, орос хэлээр 2579, монгол хэлээр 1168, нэмэлт шошго наасан 11850 байна.<br>Тандалт судалгаанд хамрагдсан хүнсний барааны тээвэрлэлтийн байдлаар авч үзвэл: Чингэлэг энгийн 6319, хөргүүртэй 1309, Вагон: ачааны зориулалттай 906, хөргүүртэй 194, Ачааны автомашин: нийтлэг зориулалттай 1003, хөргүүртэй 11116, Агаарын хөлөг 1809, бусад 135 тээврийн хэрэгслээр тээвэрлэгдсэн байна.<br>Хяналт шалгалтаар 15 аж ахуйн нэгж, 13 иргэнд холбогдох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 28 зөрчлийг илрүүлэн 29,410.000 төгрөгийн торгуулийн ногдуулан төлбөрийг 100% барагдуулж, 4 зөрчил нь тээвэрлэлтийн шаардлага хангаагүй ба 24 зөрчил нь шошгын шаардлагаар зөрчил илэрч холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн.<br><br>9.ЭЗХЯ, ШС-ын ажлын албаны холбогдох чиглэлийн 2 ажлын хэсэгт ажиллаж, яам, агентлагуудаас зохион байгуулсан 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт орж, санал, зөвлөмж өгсөн.<br><br>10.2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар ХЦХ-ээс 1 сургалт зохион байгуулсан бөгөөд хорио цээрийн мэргэжлийн болон бусад чиглэлээр 6 сургалтад хамрагдсан байна.<br><br>**Хүрсэн үр дүн:**<br>Шадар сайдын санаачлагаар хийгдсэн хүнс, эм, барилгын материалын хэлэлцүүлэгт санал өгч, хорио цээрийн хяналтад хамрагдаж барааны зөрчил болон хяналт шалгалтын үр дүнд үнэлгээ хийж, импортын хүнсний тандалтын удирдамжийг хүргүүлж, биелэлтийг тооцсон. Түүнчлэн холбогдох яам, агентлаг, удирдах байгууллагын 3 ажлын хэсэгт ажиллан, 8 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт орж, санал, зөвлөмж өгсөн. | |
| 3 | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын чиглэлээр дэд бүтцийг | 1.Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх "Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааны төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралдаанд 2024 оны 05 | 1.“Хилийн үр ашгийг нэмэгдүүлэхэд тогтвортой худалдаа төсөл”-ийн хүрээнд Хавирга, Цагааннуур, Булган хилийн боомтын ерөнхий төлөвлөгөөнд халдваргүйжүүлэлтийн | 1. Барилгын хөгжлийн төвд Алтанбулаг, Боршоо хилийн боомтын ачаа тээврийн халдваргүйжүүлэлтийн байгууламжийн техникийн тодорхойлолтыг 2025 оны 04 сарын 23-ны өдрийн 02-1.2/1665, 025-1.2/1677 дугаартай албан бичгээр хүргүүлэн ажилласан.<br><br>Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ээлжит хуралд оролцож, Шивээхүрэн, Гашуунсухайт, Хавирга боомтын | 95 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | чадавхжуулсан байдал | дугаар сарын 06-09 -ний өдрүүдэд оролцож, “BEST” төслийн хүрээнд Хавирга, Цагааннуур, Булган боомтын өргөтгөл, шинэчлэлийн төслийн асуудлаар хэлэлцэж, “Нэг-Эрүүл мэнд” бодлогын хүрээнд хийгдэх ажлын саналыг өгсөн.<br>Бичигт, Булган хилийн боомтын цогцолборын зураг төсөлд санал өгсөн.<br>2.ГЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 132 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хороо батлуулах тухай” ажлын хэсэгт ажиллан, Алтанбулаг, Боршоо боомтод төслийн шугамаар баригдах халдваргүйжүүлэлтийн байгууламжийн техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж, тус ажлын хэсэгт өгсөн.<br><br>ГЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 130 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хороо батлуулах тухай” ажлын хэсэгт ажиллан, 7 газар, хороонд 8 термокамера нийлүүлэх нээлттэй тендерийг шалгаруулж, нийлүүлэгч компанийг | байгууламж, бохир усны цэвэрлэх байгууламж, ундны усны хамгаалалтын бүс, хорио цээртэй барааг түр байршуулан халдваргүйжүүлэх болон хариу арга хэмжээ авах зориулалттай эрүүл ахуйн бүсийг ажлын зурагт тусгуулах саналыг хүргүүлж, захиалагчийн явцын хяналтыг хийнэ.<br><br>2. Сэлэнгэ аймаг дахь ГГ-ын Алтанбулаг хилийн боомт, Увс аймаг дах ГГ-ын Боршоо хилийн боомтуудад халдваргүйжүүлэлтийн байгууламжийг барьж байгуулах ажлын хүрээнд барилга угсралт, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, турших шалгах, хүлээх авах ажилд захиалагчийн хяналтыг тавьж ажиллана.<br><br>3. ОУЭМД-ийн дагуу хилийн нэвтрэн орох цэгт ноцтой байдлын үед боомтын бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд хорио цээрийн хяналт хийхэд зайлшгүй шаардлагатай барилга байгууламж, талбай, техник, тоног төхөөрөмжийн суурь судалгааг шинэчлэн гаргаж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангуулах саналыг 2026 оны улсын | ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй танилцаж, хорио цээрийн хяналтын чиглэлээр санал өгч ажилласан.<br><br>“Циркул проект” ХХК-ниас ирүүлсэн “Цагааннуур чөлөөт бүсийн 2025-2027 оны бүтээн байгуулалтын төлөвлөгөө”-тэй танилцаж, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж буй ажлын хэсгийн хүсэлтийн дагуу зохион байгуулсан уулзалтанд оролцож, санал солицож ажилласан.<br><br>**Хүрсэн үр дүн:**<br>3 боомтын шинэчилсэн төлөвлөлтэд саналыг өгч, харьяа гаалийн газар, хороод шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдаж, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сонгож, худалдан авалт хийгдэхээр болсон.<br><br>3.Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг боомтод халдваргүйжүүлэлтийн байгууламжийг барьж байгуулах нээлттэй тендерийн холбогдох материалд "Хилийн боомтын нэвтрэн орох цэгт автотээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар"-ын төсөл, ерөнхий төлөвлөгөөний зургийн дагуу боомтын нэвтрэн орох хэсэгт зорчигчийн болон ачаа тээврийн халдваргүйжүүлэлтийн байгууламжийг тус тусад барьж байгуулах шийдвэрийг гаргуулсан. | төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулна. | | |
| 4 | Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олголт, тэдгээрт хяналт тавьсан байдал | 1.ГЕГ-ын apqs.gaali.mn системээр ирүүлсэн экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийн шуурхай шийдвэрлэлт, гаалийн газар, хороодоос олгож буй импортын гэрчилгээний олголтод хяналт тавьж ажилласан.<br><br>2024 оны эхний хагас жилийн байдлаар БНХАУ-д 3853,5тн адууны мах, 6426,5тн дулааны аргаар чанаж боловсруулсан үхэр, | 1.Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагааны талаар чиглэл, зааврыг хүргүүлж ажиллана.<br><br>2.Импортын гэрчилгээ олголтыг хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.<br><br>3.Харьяа гаалийн газар, хороодоос мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд цахимаар | 1. Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах албан тушаалтны гарын үсэг, тамганы дардас, гэрчилгээ мэдэгдлийн загварыг Хорио цээрийн хэлтсээс харьяа гаалийн газар хороодод 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02-1.2/1241 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагааны талаар БНХАУ-ын ГЕГ-т 2025.01.16-ны өдөр 02/226 тоот, 2025.02.04-ний өдөр 02/578 тоот, 2025.02.07-ны өдөр 02/618 дугаартай албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн.<br><br>2.Импортын гэрчилгээ олголтыг хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллаж, импортын гэрчилгээ цахимжуулах тестийг хийж, КАЙС системийн хорио цээрийн системд нэвтрүүлэхэд бэлэн болгосон. Харьяа гаалийн газар, хороод дээр импортын гэрчилгээ олголттой холбоотой | 95 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хонь, ямааны мах, 71,77,5тн хонь, ямааны Иран, Ирак, Азербайджан, Узбекистан, Вьетнам улсад тус тус экспортлоход, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бараанд дамжин өнгөрүүлэх мэдэгдэл 79 ширхэг, импортын мэдэгдэл 1175 ширхэгийг Гаалийн ерөнхий газар, газар, хороодоос цахимаар олгоход мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан. | олгох "Импортын гэрчилгээ"-г боловсронгуй болгож, хяналт, шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр Мэдээллийн технологийн газартай хамтран ажиллана. | зөрчил, дутагдал илрээгүй. Гаалийн ерөнхий газраас Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 97, импортын мэдэгдэл 509, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл 140, БНХАУ-д гурил экспортлох гэрчилгээ 82 тус тус олгоход харьяа гаалийн газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангасан.<br>Ургамал хамгааллын газартай 2025.01.15, 2025.01.22, 2025.02.26-ны өдрүүдэд 3 удаагийн уулзалт хийж, хурлын шийдвэрийг гаргаж, 2025.03.01-ний өдрөөс Ургамал хамгааллын газар гэрчилгээ, мэдэгдлийг хүлээлгэн өгсөн.<br>Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн, үйлдвэрийн яамнаас ирүүлсэн 2025 оны 02 дугаар сарын 07-өдрийн санал авах тухай 02/403 дугаартай “Импортын мэдэгдэл олгох мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалт”-ыг боловсруулж батлуулах албан бичгийг хариуг 2025.02.24-ний өдөр 02/865 дугаартай албан бичгээр БТКУС-ын кодыг нарийвчлан гарган хүргүүлсэн.<br><br>3.Гаалийн байгууллагаас олгож буй Импортын гэрчилгээний загварыг шинэчлэн Мал, амьтны болон мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гэсэн 2 төрөлтэй болгохоор эцэслэн боловсруулсан.<br>Импортын гэрчилгээний загвар шинчлэгдэж буйтай холбогдуулан Хорио цээрийн системийн дэд цэсийг шалгаж сайжруулалт боловсруулалтын санал өгч, ажилласан.<br>"Импортын гэрчилгээ”-ний шинэчилсэн загвар дээр Мэдээллийн технологийн газартай нэгдсэн зөвшилцөлд хүрсэн.<br>2025 оны 05 дугаар сарын 28- ны өдөр Хорио цээрийн цахим системээс “Импортын гэрчилгээ”-г олгох болсонтой холбогдуулан Тэмдэгтийн хураамж авах, төлбөр, тооцоог цахим сувгуудыг ашиглан хялбараар төлөх гарцуудыг нээх асуудлын хүрээнд Интерактив ХХК-ийн төлөөлөл, МТГ болон СХОГ-ын дарга, чиглэлийн гаалийн улсын байцаагчидтай уулзалт зохион байгуулж, шийдлийг танилцуулж шийдвэрлэсэн.<br>**Хүрсэн үр дүн:**<br>Импортын гэрчилгээ олголттой холбоотой зөрчил, дутагдал илрээгүй, харьяа гаалийн газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж, “Импортын гэрчилгээ”-цахимаар олгох нөхцлийг бүрдүүлсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд тавьсан хяналт | 1.2024 оны эхний хагас жилд хорио цээрийн хяналтад хамрагдсан барааны лабораторийн шинжилгээний дүн, мэдээнээс харахад нийт 532,8 мян.тн, 6.355.978 ширхэг, 54 хайрцаг бараанаас 12118 удаа 27,7 тн барааг шинжилгээнд хамруулсан байна.<br>Нийт шинжилгээнд хамрагдсан бараа нь 61946 үзүүлэлтээр шаардлага хангаж, 106 үзүүлэлтээр шаардлага хангаагүй гарсан нь урьд оны мөн үеэс 27 үзүүлэлтээр илүү байна.<br>2.Лабораторийн итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулан ажиллаж, МЭЕГ, ХАБҮЛЛ зэрэг төрөлжсөн лабораторийн удирдлагуудтай ГЕГ-ын даргын 2024 оны 115 дугаар тушаалаар батлагдсан Хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсэг уулзалт хийж, цахимаар өгөгдөл солилцох асуудал дээр тохиролцов. | 1.Хяналтын чиглэл бүрээр лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо хэмжээ, үзүүлэлтийн тайланг сар бүр нэгтгэн, удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллана.<br>2.Лабораторийн шинжилгээгээр зөрөг буюу шаардлага хангаагүй гарсан барааны дүнд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, энэ чиглэлээр газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.<br><br>3.Хорио цээрийн лабораторийн итгэмжлэл, шинжилгээний бодит, байдал, чадавхыг сайжруулах хүрээнд төсөл, хөтөлбөрийн болон мэргэжлийнн байгууллагатай хамтран үнэлгээ хийж, санал боловсруулна.<br>4.Хил дамнасан усны 5 цэгт хийх эрүүл ахуйн шинжилгээтэй хяналтын удирдамжийг боловсруулан Сэлэнгэ аймгийн Гаалийн газарт хүргүүлж, шинжилгээний дүнг ОХУ, Монгол Улсын ЗГ-ын Хилийн усыг ашиглах, хамгаалах хэлэлцээрийг хэрэгжүүлэх ээлжит хуралдаанд танилцуулна. | 1. Хорио цээрийн экспортын хяналтаар 13.6 мян.тн бараа бүтээгдэхүүнээс 369 удаа 698 кг бараа, бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулсан байна. Нийт шинжилгээнд хамрагдсан бараа, бүтээгдэхүүнээс 1905 үзүүлэлтээр шаардлага хангаж, шинжилгээний төлбөр болох 13,3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.<br>Импортын барааны лабораторийн шинжилгээнд хамруулсан мэдээгээр 658.3 мян.тн бараа бүтээгдэхүүнээс 8924 удаа 18.2 тн бараа, бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулахад 50000 үзүүлэлтээр шаардлага хангаж, 60 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна. Шинжилгээний төлбөр болох 608,3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.<br>Импортын лабораторийн шинжилгээт хяналтад сонгогдсон барааны /658.3 мян.тн буюу 18.2 тн/ 0,003 хувь дээжийг шинжилсэнээс 50000 үзүүлэлт буюу 99.9 хувь шаардлага хангаж, 60 үзүүлэлт буюу 0.1 хувь нь шаардлага хангахгүй дүнтэй гарсан.<br>2. Лабораторийн шинжилгээгээр зөрөг буюу шаардлага хангаагүй гарсан барааны дүнд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, энэ чиглэлээр газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.<br>Лабораторийн шинжилгээгээр зөрөг буюу шаардлага хангаагүй тохиолдлууд болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дурьдвал:<br>Замын-Үүд боомтоор 2 дугаар сард 845.9 тн /хүнсний ногоо/ чинжүүний сорьцноос Хүнс, хөдөө аж ахуйн сайдын А-100 тоот тушаалын хавсралтад бүртгэгдсэн Монгол улсад хязгаарлагдмал тархалттай хөнөөлт шавж болох Хүлэмжийн цагаан далавчтан (Trialeurodes vaporariorum) 4 ширхэг /үхсэн/ илэрч, халдваргүйжүүлэлт хийж хилээр нэвтрүүлсэн.<br>- Цэцэг 34.9 тн, Башир цэцгийн дээжинд-Шулхий хачиг, Удвал цэцгийн дээжинд-Хүлэмжийн цагаан далавчтан Сараана, Удвал, Башир, Сарнай цэцгийн дээжинд-Ургамлын бөөс, Удвал цэцгийн дээжинд-Цацаг далавчтан илэрсэн. Халдваргүйтгэл хийж нэвтрүүлсэн.<br>- Замын-Үүд боомтоор 3 дугаар сард 467.5 тн /хүнсний ногоо/ Цоо байцааны дээжинд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын А-100 тоот тушаалын хавсралтад бүртгэгдсэн Монгол улсад хязгаарлагдмал тархалттай хөнөөлт шавж болох байцааны бөөс--5 ш /амьд илэрч, 2219.7 тн /хүнсний ногоо/ Цоо байцааны дээжинд Цацаг далавчтан--3 ш /үхсэн/ илэрч, Цоо байцааны дээжинд | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Цацаг далавчтан-4 ш /амьд/ илэрч, 14 тн цэцгэнд Удвал цэцгийн дээжинд Цацаг далавчтан -2ш /үхсэн/ илэрч халдваргүйжүүлэлт хийж хилээр нэвтрүүлсэн.<br>- Алтанбулаг боомтоор 3 дугаар сард 40 тн гичийн үрэнд дотоод хорио цээртэй хачиг илэрч, ариутгал халдваргүйтгэл хийж нэвтрүүлсэн.<br><br>**Хүрсэн үр дүн:**<br>Хорио цээрийн чиглэлээр газар, хороодоос лабораторид шинжилгээнд хамруулсан мэдээг авч чиглэл бүрээр 7 хоног, сар, улирлаар авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээ мэдээллээр ханган ажиллахад чиглэл өгсөн. | |
| 6 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлсэн байдал | 1. ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/115 дугаар тушаалаар батлагдсан Хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсэг хорио цээрийн хяналтад хамрагдах барааны эрсдэлийн шалгуурыг боловсруулж эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж улаан төлөвт шалгагдах барааны тоог бууруулах судалгааг хийж, Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй 3 удаагийн уулзалтыг хийж, хорио цээрийн эрсдэлийн шалгуурыг гаалийн эрсдэлийн шалгууртай уялдуулан тооцох программын даалгаврыг боловсруулсан.<br><br>2.“Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх журам”-ын хорио цээр, эрүүл ахуй, | 1.Хорио цээрийн хяналтад хамрагдах барааны эрсдэлийн шалгуурыг боловсруулж эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж улаан төлөвт шалгагдах барааны тоог бууруулах<br><br>2.Хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгох<br><br>3.Гаалийн эрсдэлийн нэгдсэн удирдлагын журмыг ЭУХ-тэй хамтран боловсруулж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгоход санал өгөх<br><br>4.Экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл зэрэг баталгаажуулалтын баримт бичгийн олголт Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжиж буйтай холбогдон бэлтгэл | 1.ГЕГ-ын даргын 2024 оны А/115 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу Азийн хөгжлийн банкнаас “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн хэрэгжүүлсэн ажил 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар 90 %-ийн гүйцэтгэлтэйгээр ажиллав.<br>Энэхүү цахимд суурилсан үйл ажиллагааг нэвтрүүлсэнээр хорио цээрийн хяналт шалгалтад хамаарах барааны биет үзлэгийн тоог эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар тодорхой түвшинд хүргэж бууруулахад ач холбогдол өгсөн. Үүнд:<br>-Зорчигчийн хувийн хэрэглээний эмийн цахим бүртгэл - 95 хувь<br>- Цацрагийн цахим бүртгэл-90 хувь<br>-Хорио цээрийн үйл ажиллагааны цахим заавар-80 хувь<br>-Хэрэглэгчийн удирдлагын модулиудын бүртгэлийн системийг цахимд нэвтрүүлэх,туршилтын тест-95- хувь<br>- Сэрэмжүүлэг мэдэгдэл-90 хувь<br>- Гэрийн тэжээвэр амьтны бүртгэл -95 хувь<br>- Олон улсын хөл хориот халдварт өвчний бүс нутгийн бүртгэл-90<br>-Тус тусгаарлалтын модуль-95 хувь<br>-Зөрчлийн бүртгэлийн модуль-85 хувь<br>-Эрсдэлийн нэгдсэн удирдлагын модуль-80 хувь<br>-Шарилын бүртгэл-95 хувь<br>2.Эрсдэлийн удирдлагын хэлтсээс дотоод албан бичгээр ирүүлсэн НВЦ ХХК-ийн импортлож буй хүнсний өндгөнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх тухай дотоод албан бичгийн дагуу судалгаа хийж ЭУХ-т хүргүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангасан. | 90 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
